

Хүүхдэд зориулсан Библи  
танилцуулж байна



Бурхнаас  
илгээгдсэн  
Нэгэн



**Зохиогч: Edward Hughes**

**Зураглаач: Byron Unger; Lazarus**

**Найруулсан: E. Frischbutter; Sarah S.,  
Alastair Paterson**

**Орчуулсан: Damdin Norolsuren**

**Бүтээсэн: Bible for Children  
[www.M1914.org](http://www.M1914.org)**

**©2020 Bible for Children, Inc.**

**Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах  
эрхтэй харин худалдахыг хориглоно.**



**Нэгэн өдөр Бурхны сүмд Захариа  
нэртэй нэгэн тахилч утлага уугиулж  
байв. Гадаа нь хүмүүс  
залбирцгааж байлаа.  
Гэнэт Захариа  
айж сандрав.**



**Тэнгэр элч түүн дээр ирээд "Бүү ай"  
гээд "Бурхан намайг чамруу явуулсан.**

**Эхнэр чинь хүү  
төрүүлэх болно.**



**Түүнийг Иохан гэж дуудах болно.**

**Тэр ариун сүнсээр дүүрэн  
нэгэн болно.**



**Тэр олон хүнийг Бурхан уруу  
эргүүлэх болно" гэв.**



**"Бидэнд юу болсон  
тухайгаа яриач  
Захариа" гэж гадаа  
хүлээж байсан**

**ХҮМҮҮС  
ШАЛАВ.**



**Тэд тэнгэр элч  
Габриел Захариад  
юу гэж хэлснийг  
мэдсэнгүй учир нь  
тэр Бурхны үгэнд  
итгээгүй ...**





**... учир хүүхэд төрөх хүртэл хэлгүй  
болж ярьж чадахгүй болсон  
байв. Тэр эхнэр нь  
хүүхэд төрүүлэхэд  
дэндүү оройтсон  
гэж боджээ.**



**Тэр эхнэр нь  
хүүхэд төрүүлэхэд  
дэндүү оройтсон  
гэж боджээ.**



**Гэртээ ирээд Захариа тэнгэр  
элч юу хэлсэн тухай цаасан  
дээр бичив. Түүний эхнэр  
Елизабет ихэд гайхжээ.**



**Тэд хүүхдийн төлөө үргэлж  
залбирч байжээ. Хүүхэд  
төрсөн болов уу?**





**Удалгүй  
Елизабет  
хүүхэдтэй  
болсноо мэдэв.  
Тэр Бурхныг  
магтав.**





**Нэгэн өдөр,  
Елизабетын  
үеэл дүү  
Марияа  
тэдний гэрт  
ирэв. Мария  
бас хэвлийдээ  
хүүхэдтэй  
байлаа.**






**Марияаг  
ирэх үед  
Елизабетын  
хэвлий дэх  
хүүхэд нь  
хөдлөв.**





**Марияаг ирэх үед Елизабетын  
хэвлий дэх хүүхэд нь хөдлөв.  
Елизабет ариун сүнсээр дүүрэв.**



**Тэр Марияагийн  
хэвлий дэх  
хүүхэд Эзэн  
Христ Есүс  
гэдгийг мэдсэн  
юм.**





**Елизабетын хүүхэд  
Бурхны амласнаар  
төрөв. Ахлах тахилч  
нар "Хүүг эцэгтэй нь  
адилаар Захария гэж  
нэрлэе" гэцгээв.**




**Захария Бурхны  
зарлигийг санав.  
"Үгүй! Хүүг  
Иохан гэж нэрлэх  
болно" гэж цаасан  
дээр бичив.**




**Түүнийг ийнхүү  
бичиж байхад түүний  
ярих чадвар нь буцаж  
ирэв. Тэгээд тэр  
Бурхныг магтав.**



**Иохан Бурхнаас илгээгдсэн хүн Елиа шиг өсжээ. Иохан хүмүүст Аврагч тэднийг ерөөхөөр удахгүй ирэх болно гэж хэлсээр байлаа.**



**Иудачүүдийн ахлагч  
нар Иоханыг үзэн  
ядаж байв учир нь  
тэр тэдэнд "Гэмш!  
Нүгэл үйлдэхээ  
боль" гэжээ.**



**Тэд өөрсдийн  
нүглийн талаар  
сонсохыг  
хүсэхгүй байв.**



**Бусад нь түүнийг Баптизм  
хүртээгч Иохан гэдэг байв  
учир нь тэр  
хүмүүсийг  
гэмийн  
уучлалын  
төлөө  
тэднийг  
усанд  
бүх ...**



**... биеэр нь оруулж  
баптизм хүртээж  
байсан юм.  
Нэгэн өдөр  
Есүс Иохан  
дээр  
баптизм  
хүртэхээр  
ирэв.**





**Иохан "Би танаар баптизм хүртэх  
ёстой атал та надруу ирнэ**

**үү" гэхэд Есүс  
"Хүслээр минь  
хийгтүн" гэв.**

**Тэгээд  
Иохан  
түүнд  
баптизм  
хүртээв.**



**Есүсийг  
баптизм  
хүртэж байх  
үед ариун сүнс  
ирж Есүсийн  
дээр тагтаа  
МЭТ ТОГТОН  
байхыг Иохан  
харав.**



**Энэ бол  
Бурхны  
ТЭМДЭГ байв.  
Иохан Есүс  
бол Бурхны  
хүү гэдгийг  
мэдэж байлаа.**



**Иохан  
түүнийг  
энэ дэлхийг  
гэмийг үүрсэн  
Бурхны Хурга  
хэмээн дуудав.**



Иохан олон хүнийг Бурхан уруу  
эргүүлэв. Ёс бус захирагч Херод



Иоханыг барьж  
авч шоронд  
хорьжээ. Учир нь  
Иохан Херодод  
"Өөрийн дүүгийн  
эхнэр Херодиаг  
эхнэрээ болгон  
авсан тань

нүгэл" гэж зэмлэжээ.



Херод түүнийг хэлж байгаа үнэн  
гэдгийг мэдэж байв. Тэр Иохан бол

Бурхны  
үйлчлэгч ариун  
нэгэн гэдгийг  
мэдэж байлаа.





Харин тэр  
гэм хийхээ  
зогсоохыг  
хүсэхгүй байв.  
Иохан шоронд  
байсан ч  
гэмшигтун  
хэмээн  
тунхагласаар  
байлаа.




**Херодын төрсөн өдөр болж  
том найр хийв. Херодиагийн  
охин Херодод зориулж бүжиг  
бүжиглэв.**






**Тэр Херодын тааллыг олов. Тэр  
"Хүслээ хэл чамд юу хүссэнийг  
чинь өгнө хаант улсынхаа  
талыг өгөөч гэсэн ч өгөх  
болно" гэж амлав.**



**Охин "Юу  
гуйх вэ"  
гэж бодов.**





**Түүний ёс бус  
эх Херодиа  
Иоханыг үзэн  
яддаг байсан  
бөгөөд  
охиндоо гуйх  
зүйлийг нь  
зааж өгөв.  
Тэр нь  
аймшигтай  
хүсэлт байв!**



Охин Херодод "Надад  
баптизм хүртээгч  
Иоханы толгойг  
тавган дээр тавиад  
авч ирнэ үү" гэв. Тэр  
ам гарсандаа  
харамсаж байв ч  
хэлснээсээ буцахад  
оройтсон  
байлаа.



Херод "Иоханы  
толгойг аваад энд  
авч ир" гэж тушаав.  
Цэргүүд түүний  
хэлснээр  
хийв.



**Бурхны зоригтой  
итгэмжит зарц  
Иоханыг  
найзууд нь  
гунигтайгаар  
оршуулав.**



**Иоханы хийх  
ёстой Бурхны ажил  
хараахан дуусаагүй  
байлаа. Тэд  
Есүс тэдний  
уй гашууг  
тайтгаруулж  
чадна гэдгийг  
мэдэж байсан  
ч байж  
магадгүй.**



Бурхнаас илгээгдсэн Нэгэн

Бурханы үг Библиээс авсан түүх

Марк 6, Лук 1, 3

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."

Дуулал 119:130





**Төгсөв**



Библийн түүх нь гайхамшигт Бурхан биднийг бүтээсэн бөгөөд таныг өөрийгөө мэдээсэй гэж хүсдэг тухай бидэнд хэлдэг.

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид үргэлж хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл боловч Бурхан танд маш их хайртай учир Тэрээр цорын ганц хүү Есүсийг таны гэмийн өмнөөс шийтгүүлэн загалмайд цовдлогдон үхэхийг зөвшөөрөн энэ дэлхийд илгээсэн юм. Тэгээд Есүс дахин амилж тэнгэр дэх гэртээ буцсан! Хэрвээ та Есүст итгэж түүнээс гэмийнхээ төлөө уучлал гуйвал Тэрээр таныг уучлах болно! Тэрээр таньруу ирэх бөгөөд тантай хамт байх болно мөн та түүнтэй мөнхөд хамт амьдрах болно.



Хэрвээ та энэ үнэнд итгэж  
байвал Бурханд хандан ийнхүү хэлээрэй:  
Эрхэм Есүсээ, Би таныг Бурхан гэдэгт болон  
миний гэмийн төлөө үхсэн гэдэгт мөн одоо та  
амьд гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж  
ирээд миний гэмийг уучлаач, тэгээд Би одооноос  
эхлээд шинэ амьдралаар амьдарч нэг өдөр  
тантай хамт мөнхөд байхаар явах болно. Танд  
дуулгавартай байж таны хүүхэд шиг таны төлөө  
амьдрахад туслаач. Амен.

Библи уншиж өдөр бүр Бурхантай  
ярилцаарай! Иохан 3:16

